

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “тангараглая” гэсний өмнө “хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байхаа” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 9.1.1,” гэсний дараа “9.1.4, 9.1.5,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“9.4.Энэ хуулийн 9.2-т заасан гишүүнийг чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, энэ хуулийн 9.1.2, 9.1.3-т заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөхийг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.”

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “биелүүлэхээ” гэснийг “биелүүлж,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “гаргасныг” гэснийг “гаргасан” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” гэснийг, 9.2 дахь хэсгийн “, энэ хуулийн 9.1.4, 9.1.5-д заасан тохиолдолд эгүүлэн татах” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын 2028 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг